

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Дархан сумын Хоршоог хөгжүүлэх сан 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2024/54/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www. Shinjenmagadlahui. ezsh.audit.mn Улаанбаатар хот 2024 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ш.Мөнхбаяр Утас: 70373089, 99023682 Цахим хаяг: Munkhbayarsh@audit.gov.mn Аудитын менежер: У.Батсүрэн Утас: 99036806 Цахим хаяг: Batsurenu@audit.gov.mn Ахлах аудитор: С.Батцэцэг Утас: 99377479 Цахим хаяг: Battsetsegs@audit.gov.mn Аудит гүйцэтгэсэн: Шинжлэн магадлахуй ЭЗШ аудит ХХК Утас: 99197346, 88114867 Цахим хаяг: Shinjenmagadlahui.audit@gmail.com
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ДАРХАН СУМЫН
ЗАСАГ ДАРГА Т.ТУЛГАА ТАНАА

**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059.
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

до 24.02.23 № 52

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Дархан сумын Хоршоог хөгжүүлэх сангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дархан-Уул аймгийн Дархан сумын Хоршоог хөгжүүлэх сангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Дархан-Уул аймгийн Дархан сумын Хоршоог хөгжүүлэх сангийн 2023 оны зарцуулалт 403,828.0 мянган төгрөг бөгөөд үүний 5,977.5 мянган төгрөг буюу 1.5 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээ, 2,550.5 мянган төгрөг буюу 0.6 хувийг бараа үйлчилгээний бусад зардал, 395,300.0 мянган төгрөг буюу 97.9 хувийг эргэж төлөгдөх зээл эзэлж байна.

Аудитын гол асуудал

1. "Хоршооны тухай" хууль, Монгол Улсын Их Хурлын 2021 оны 40 дүгээр тогтоолоор Сум хөгжүүлэх санг Хоршоог хөгжүүлэх сан болон өөрчлөгдсөн бөгөөд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/361 дүгээр тушаалаар "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам" батлагдаж тус журамд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2022 оны А/243 дугаар тушаалаар нэмэлт, өөрчлөлт орсон.

2. Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны 10 сарын 04-ний өдрийн А/521 дүгээр тушаалаар "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын заалтуудад өөрчлөлт орж иргэн, хуулийн этгээд, Жижиг дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч гэснийг хасаж зөвхөн хоршоонд зээл олгохоор болсон.

009020075

Бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Дархан сумын Засаг даргын 2023 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 1 зорилтын хүрээнд 1 арга хэмжээ баталснаас гүйцэтгэлээр 97.3 хувийн биелэлттэй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.МӨНХБАЯР

A handwritten signature in black ink is written over a red rectangular official stamp. The stamp contains the Mongolian text "МОНГОЛЫН АУДИТ АГЫН ТӨСВИЙН ЗАХИРАГЧ" (State Audit Agency of Mongolia) and the identification number "9832019 517143626".

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

СТ-1А

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,043,495,898.13</u>	<u>1,111,405,711.98</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	229,941,606.13	190,748,794.98
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	229,941,606.13	190,748,794.98
3121	Төгрөг	229,941,606.13	190,748,794.98
31211	Төрийн сангийн харилцах	229,941,606.13	190,748,794.98
33	АВЛАГА	813,554,292.00	920,656,917.00
335	Бусад авлага	813,554,292.00	920,656,917.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	813,554,292.00	920,656,917.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,043,495,898.13</u>	<u>1,111,405,711.98</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,043,495,898.13</u>	<u>1,111,405,711.98</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,043,495,898.13	1,111,405,711.98
512	Хуримтлагдсан үр дүн	1,043,495,898.13	1,111,405,711.98
51210	Өмнөх үеийн үр дүн	1,043,495,898.13	1,043,495,898.13
51220	Тайлант үеийн үр дүн	-	67,909,813.85
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,043,495,898.13</u>	<u>1,111,405,711.98</u>

СТ-2А

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	19,518,324.00	76,437,763.85
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	19,518,324.00	76,437,763.85
120	Нийтлэг татварын бус орлого	19,518,324.00	76,437,763.85
120002	Хүүгийн орлого	14,553,814.00	71,561,943.85
120003	Торгуулийн орлого	-	4,875,820.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	836,250.00	8,527,950.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	836,250.00	8,527,950.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	836,250.00	8,527,950.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	836,250.00	6,122,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	836,250.00	6,122,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	2,405,450.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	2,405,450.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>18,682,074.00</u>	<u>67,909,813.85</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>18,682,074.00</u>	<u>67,909,813.85</u>

СТ-3А

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>384,877,748.00</u>	<u>364,635,138.85</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	384,877,748.00	364,635,138.85
120	Нийтлэг татварын бус орлого	384,877,748.00	364,635,138.85
120002	Хүүгийн орлого	-	21,379,542.25
120003	Торгуулийн орлого	-	4,532,986.85
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	384,877,748.00	338,722,609.75
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	384,877,748.00	338,722,609.75
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>836,250.00</u>	<u>8,527,950.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	836,250.00	8,527,950.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	836,250.00	8,527,950.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	836,250.00	5,977,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	836,250.00	5,977,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	2,550,450.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	2,550,450.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>384,041,498.00</u>	<u>356,107,188.85</u>
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	400,000,000.00	395,300,000.00
230001	Эргэж төлөгдөх зээл	400,000,000.00	395,300,000.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>(400,000,000.00)</u>	<u>(395,300,000.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(15,958,502.00)	(39,192,811.15)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		229,941,606.13
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	229,941,606.13	190,748,794.98

СТ-4А

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ Төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
-----	----------	---------------------------------	-----------------------	-------------------	--

C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	1,024,813,824.13	1,024,813,824.13
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	1,024,813,824.13	1,024,813,824.13
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	18,682,074.00	18,682,074.00
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	1,043,495,898.13	1,043,495,898.13
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	-	-	1,043,495,898.13	1,043,495,898.13
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	1,043,495,898.13	1,043,495,898.13
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	67,909,813.85	67,909,813.85
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	1,111,405,711.98	1,111,405,711.98

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	415,000,000.00	403,827,950.00	(11,172,050.00)	97.31
21	УРСГАЛ ЗАРДАЛ	9,800,000.00	8,527,950.00	(1,272,050.00)	87.02
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9,800,000.00	8,527,950.00	(1,272,050.00)	87.02
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	-	-	-

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,000,000.00	5,977,500.00	(22,500.00)	99.63
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,000,000.00	5,977,500.00	(22,500.00)	99.63
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,800,000.00	2,550,450.00	(1,249,550.00)	67.12
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,800,000.00	2,550,450.00	(1,249,550.00)	67.12
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	405,200,000.00	395,300,000.00	(9,900,000.00)	97.56
230001	Эргэж төлөгдөх зээл	405,200,000.00	395,300,000.00	(9,900,000.00)	97.56
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	384,877,748.00	364,635,138.85	(20,242,609.15)	94.74
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	384,877,748.00	364,635,138.85	(20,242,609.15)	94.74
120	Нийтлэг татварын бус орлого	384,877,748.00	364,635,138.85	(20,242,609.15)	94.74
120002	Хүүгийн орлого	-	21,379,542.25	21,379,542.25	
120003	Торгуулийн орлого	-	4,532,986.85	4,532,986.85	
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	384,877,748.00	338,722,609.75	(46,155,138.25)	88.01
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	384,877,748.00	338,722,609.75	(46,155,138.25)	88.01
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		229,941,606.10	229,941,606.10	100.00
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		190,748,795.00	190,748,795.00	100.00
1	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
2	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0.00	100.00
3	Төсвийн байгууллага	1	1	0.00	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан байхгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,100.5 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 1,100.5 мянган төгрөгийн алдааг залруулж, дахин давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

Үүнд: Тайлант жилд худалдан авсан 1,100.5 мянган төгрөгийн бараа материалыг шууд зардалд бүртгэсэн нь Сангийн сайдын 2006.11.27-ны өдрийн 388 тоот тушаалын 1 хавсралтын 4 бүлэг "Бараа материал" хэсгийн 4.21 дахь заалт "4.21 Бараа материалыг (хангамжийн зүйлийг) худалдан авсан үед: Дт. Хангамжийн материал Кт. Мөнгөн хөрөнгө / Дансны өглөг " гэсэн заалтыг зөрчсөн тул аудитын явцад залруулав.

5.1 Төлбөрийн акт

Тайлант онд төлбөрийн акт тогтоох зөрчилтэй асуудал илрээгүй болно.

5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага хүргүүлэх зөрчилтэй асуудал илрээгүй болно.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Санхүүгийн тайлантай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу санхүүгийн тайлан бэлтгээгүй, санхүүгийн тайлангийн тайлбар тодруулгыг иж бүрэн хийгээгүй нь УСНББОУС 1 "Санхүүгийн тайлангийн толилуулга", "Үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна" 8.1.5 дахь "санхүүгийн тайлангийн тодруулга" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэл, онцлог байдлыг илтгэсэн тайлбар, тодруулгуудыг хийж байх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5²-д заасан хугацаанд ирүүлж,

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Шалгаагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бараа материалын дансаар дамжуулахгүй шууд зардалд бүртгэсэн	1	1,100.5			1	1,100.5	1	1,100.5				
Дүн	1	1,100.5			1	1,100.5	1	1,100.5				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын дагуу санхүүгийн тайлан бэлтгээгүй, санхүүгийн тайлангийн тайлбар тодруулгыг иж бүрэн хийгээгүй	1						1					
Дүн	1						1					